


Хархорум музейн захирлын 2018
оны 04 дүгээр сарын 04 ны өдрийн
1/13 дугаар тушаалын хавсралт



МУЗЕЙН БЭЛЭГ ДУРСГАЛЫН ДЭЛГҮҮРТ БАРАА БОРЛУУЛАХ, ШИМТГЭЛ ТООЦОХ ЖУРАМ

Энэхүү журмаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас /Цаашид “нийлүүлэгч” гэнэ/ музейн бэлэг дурсгалын дэлгүүрээр борлуулахаар нийлүүлэх бараанд тавих шаардлага, барааг бүртгэх борлуулах, шимтгэл тооцох, тооцоо нийлэх харилцааг зохицуулна.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Бараа гэдэгт Монгол Улсын түүх, өв, соёлыг илэрхийлсэн бэлэг дурсгал сувинерын бүтээгдэхүүн, судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл, каталог, ном товхимол, сэтгүүл, CD, DVD зэргийг ойлгоно.
- 1.2. Бараа нь агуулга хийц харагдах байдал, чанарын хувьд үзэмжтэй, зохиогчийн эрхийн зөрчилгүй, холбогдох эрүүл ахуйн болон оюуны бүтээл тавигдах стандартын шаардлагыг хангасан, борлуулахаар санал болгож байгаа үнэдээ тохирсон байна.
- 1.3. Байгууллагын ажилчин өөрийн урласан бэлэг дурсгалын бүтээгдэхүүнээ музейн бэлэг дурсгалын дэлгүүрт давуу эрхтэй тавьж, борлуулна.
- 1.4. Салбарын төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага хамтарсан хайгуул, шинжилгээний ажил төслийн шугамаар хийгдсэн /ном товхимол, CD, DVD, зэрэг/-ийг байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дагуу шимтгэлгүйгээр тавьж борлуулна.
- 1.5. Музей журмын 1.3, 1.4-т зааснаас бусад борлуулсан барааны үнийн дүн тус бүрээс 20 хувиар тооцож шимтгэл авна.
- 1.6. Байгууллагын ажилчин болон журмын 1.3, 1.4-т заасан барааны үнэд тооцох шимтгэлийн хэмжээг талууд харилцан тохиролцон тогтоож болно.
- 1.7. Барааг дэлгүүрийн лангуу тавиурын хүчин чадалд тохируулан хүлээн авах ба аливаа илүүдэл барааг агуулах үйл ажиллагаа явуулахгүй.

Хоёр. Бараа хүлээн авах, бүртгэх, борлуулах, хянах

- 2.1. Нийлүүлэгч борлуулах барааны бүрэн бүтэн цогц байдлыг борлуулалт хариуцсан ажилтанд шалгуулж, тавьсан шаардлагад нийцүүлэн үнийн шошгыг наасан байна.
- 2.2. Борлуулалт хариуцсан ажилтан, нярав нар хамт байлцан Нийлүүлэгчийн барааг санхүүгийн баримт үйлдэн хүлээн авч, борлуулалтад шууд шилжүүлнэ.

Санхүүгийн баримтыг 3 хувь үйлдэх ба нярав, борлуулалтын ажилтан, нийлүүлэгч тус бүр нэг хувийг авч хадгална.

2.3. Борлуулагч нийлүүлэгч нар дэлгүүрийн барааны, эргэлтэд хяналт тавьж, нөөц нөхөн таталт хийх талаар тухай бүр эргэх холбоотой ажилна.

2.4. Борлуулалтын ажилтан борлогдсон барааны үнийн дүнгээс 20 хувиар шимтгэл тооцон авч няравт, нийлүүлэгчид ноогдох орлогыг тухайн өдөрт эсвэл дараа өдрийн 12 цагт багтаан шилжүүлж, төлбөрийн гүйцэтгэлийг баталгаажуулна.

2.5. Музейн бэлэг дурсгалын дэлгүүрт нярав тооллого хийж, холбогдох актаар баталгаажуулах ба дэлгүүрийн үйл ажиллагаанд нягтлан бодогч байнгын хяналт тавина.

2.6. Иргэн барааны эргэлт төлбөрийн гүйцэтгэлд биечлэн хяналт тавих ба музейд байнга байрлаж ажиллахгүй.

Гурав. Төлбөр, тооцоо

3.1. Борлогдсон барааны төлбөрийн тооцоог сар бүрийн эцэст гаргаж музейн санхүү болон нийлүүлэгчид мэдээлэх, тооцоо нийлэх, өр авлага барагдуулах ажлыг байгууллагын борлуулалтын ажилтан, нярав, нягтлан хариуцан гүйцэтгэнэ.

3.2. Нийлүүлэгч борлуулалтын төлбөр гүйцэтгэхэд ашиглах дансны дугаар болон холбогдох утсыг бичгээр өгнө.

3.3. Нярав, борлуулалтын ажилтан нар Нийлүүлэгчид шилжүүлсэн төлбөрийн гүйцэтгэлийг тухай бүр баримтаар баталгаажуулна.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар барааны төлбөрийн гүйцэтгэл хугацаандаа хийгдээгүй, тооцоо нийлээгүй, өглөг авлагыг тогтоосон хугацаанд барагдуулаагүй бол тооцоо хийгээгүй мөнгөний дүнд хугацаа хэтэрсэн хоног тутам 0,3 хувийн алданги тооцож буруутай эдгээдээр төлүүлнэ.

4.2. Төлбөрийг буруу олгох, хувийн зорилгоор ашиглах, зарцуулах, худал мэдээлэх зэргээр үүргээ хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй, баримт бүрдүүлээгүй зэргээс хохирол учирбал хохирлыг буруутай этгээд бүрэн буюу хэсэгчлэн барагдуулна.

4.3. Нийлүүлэгчийн буруутай үйлдлээс барааны чанартай холбоотой гологдол эвдрэл, гэмтэл, тоо ширхэгийн буруу мэдээлэл бүртгэл, тооцооны баримтад гарын үсэг зураагүй зэргээс болон байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс үүдсэн аливаа хохиролыг музей болон ажилтан хариуцахгүй.